



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 119

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль сахиулахын их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 16,513,290.00 (арван зургаан сая таван зуун арван гурван мянга хоёр зуун ерэн) төгрөгийн балансын үнэ, 14,132,338.17 (арван дөрвөн сая нэг зуун гучин хоёр мянга гурван зуун гучин найман төгрөг арван долоон мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Өмнөговь аймаг дахь Хилийн цэргийн 0131 дүгээр анги, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт балансаас балансад тус тус шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001651



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн  
119 дугаар тогтоолын хавсралт



ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Принтер (epson L1800)	2017.06.27	Ш	1	1,699,900.00	1,699,900.00	254,985.00	1,444,915.00	Өмнөговь аймаг дахь Хилийн цэргийн 0131 дүгээр анги
2	Телевизор (samsung-49)	2017.06.28	Ш	1	1,697,400.00	1,697,400.00	254,610.00	1,442,790.00	
3	Компьютер (I5)	2017.06.28	Ш	4	1,171,500.00	4,686,000.00	702,900.00	3,983,100.00	
4	Телевизор (Монел 39)	2017.07.05	Ш	1	629,990.00	629,990.00	94,498.50	535,491.50	
5	Ширээ	2017.06.30	Ш	2	230,000.00	460,000.00	43,125.00	416,875.00	
6	Сандал	2017.06.30	Ш	8	80,000.00	640,000.00	80,000.00	560,000.00	
7	ДДэш ТВ	2017.07.06	Ш	1	180,000.00	180,000.00		180,000.00	
	Дүн			18		9,993,290.00	1,430,118.50	8,563,171.50	
1	Медикро спирометр	2017.02.10	Ш	1	6,520,000.00	6,520,000.00	950,833.33	5,569,166.67	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
	Дүн					6,520,000.00	950,833.33	5,569,166.67	
	Нийт дүн					16,513,290.00 (арван зургаан сая таван зуун арван гурван мянга хоёр зуун ерэн)	2,380,951.83 (хоёр сая гурван зуун наян мянга есөн зуун тавин нэгэн тегрэг наян гурван мөнгө)	14,132,338.17 (арван дөрвөн сая нэг зуун гучин хоёр мянга гурван зуун гучин найман тегрэг арван долоон мөнгө)	